



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/516

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4(в), 29.2, Авто замын тухай хуулийн 6.1.1, 6.1.3 Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16,6, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны IV хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Усархаг борооны улмаас Баян-Өндөр сумын Дэнж багийн хэсэгт шороон зам эвдэрч авто машин явахад хүндрэлтэй байгааг сэргээн засварлах, Нарлаг Дэнжийн 74 дүгээр гүний худгийг лайдах, зарим орон сууцны байрны дээвэр засварлахад шаардагдах 43539748 /Дөчин гурван сая таван зуун гучин есөн мянга долоон зуун дөчин найман/ төгрөгийг болзошгүй аваарийн зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг /-т зөвшөөрсүгэй.

2.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хотын захирагчийн алба /н.Түмэнжаргал/-д даалгасугай.



Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны
7 дугаар сарын 27-ны өдрийн
27 дугаар захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН БАРИЛГЫН ЗАСВАРЫН
АЖЛЫН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

| № | Зардлын нэр | Зардал / төгрөг/ |
|------|--|------------------|
| 1 | Баян-Өндөр сум Дэнж баг.Нарлаг дэнжийн 74 дүгээр гүний худгийг лайдах ажил | 3604781 |
| 2 | Орон сууцны 5-р хорооллын 21-р байрны 2-р блокын дээвэр засварын ажил | 11817086 |
| 3 | Дэнж багийн шороон замын хэсэгчилсэн засварын ажил | 28117881 |
| Нийт | | 43539748 |